



**НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 1/08

Улаанбаатар хот

**Г Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн  
зөвлөл байгуулах тухай**

Монгол улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.6, Хөдөлмөрийн сайдын 2015 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/114 дүгээр тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1. Тус газрын алба хаагч нарын эрүүл мэнд, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, ажлын зохистой орчныг бүрдүүлэх, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчинөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл"-ийг байгуулсугай.
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
3. Тушаал гарсантай холбогдуулан дүүргүүдийн Онцгой байдлын хэлтсүүдэд салбар зөвлөл байгуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, зөвлөлийн үйл ажиллагааны тайланг 06 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны дотор танилцуулж байхыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн дарга, хурандаа Д.Мөнхсайханд даалгасугай.
4. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын хэлтэс (дэд хурандаа Б.Баттулга)-т даалгасугай.

ДАРГА,  
ХУРАНДАА

Ж.ЧУЛТЭМСҮРЭН



Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын  
2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн  
08 дугаар тушаалын хавсралт



**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,  
ЭРҮҮЛ АХУЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Зөвлөлийн дарга:

Гал түймэртэй тэмцэх хэлтсийн дарга,

Гишүүд:

Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга,

Дотоод хяналт, шинжилгээ, үнэлгээ  
эрсдэлийн удирдлагын тасгийн дарга,

Захиргааны удирдлагын хэлтсийн хүний  
нөөц, бие бүрэлдэхүүний сургалт хариуцсан  
ахлах мэргэжилтэн,

Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн  
нийгмийн эрүүл мэндийн асуудал  
хариуцсан мэргэжилтэн,

Нарийн бичиг:

Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Хөдөлмөр  
хамгаалал хорт хий утаанаас хамгаалах  
асуудал хариуцсан мэргэжилтэн

---оо---